

**Нэгдүгээр бүлэг.**

**УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР**

Төрийн аудитын тухай хуулийн дагуу УИХурлын Төсвийн байнгын хорооноос баталсан аудит хийх сэдэв, ҮАГ-ын төлөвлөгөөний дагуу УИХурлын хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх болон төсвийн хөрөнгийн арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор санхүүгийн болон гүйцэтгэл, нийцлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмжүүд гарган хуульд заасан чиг үүргээ амжилттай хэрэгжүүлж ажиллаа.

Төрийн аудитын байгууллагын хэмжээнд САХИЛГА ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ жил болгон зарласантай холбогдуулан тус газраас ажилтнуудад ажлын чанарыг сайжруулах шаардлагыг тухай бүрд тавьж, албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулахаар хурууны хээгээр цаг бүртгэх төхөөрөмж байрлуулж, сар бүр цагийн тооцоог хийж, тайлант хугацаанд МУЕАудиторын тушаалаар шинэчлэн баталсан бүтэц, 12 орон тоотойгоор, нийт 24960 хүн цаг ажилласан байна.

Тэргүүлэх аудитор ажилтнуудтай 2017 оны үр дүнгийн гэрээ байгуулж, баталгаажуулсан ба хагас, бүтэн жилийн үр дүнгийн гэрээг дүгнэж ажиллаа.

Урд оны болон 2017 оны аудитаар тавигдсан акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах сарын аяны ажлын төлөвлөгөө боловсруулан баталж, тавьсан акт, албан шаардлага, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн явцад хяналт тавьсан.

Ерөнхий аудиторын орлогч С.Бүрэнбатаар ахлуулсан шалгалтын ажлын хэсэг тус байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудитыг явуулж, ҮАГ-н Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн цаашид анхаарч ажиллах зөвлөмж, чиглэл, үүрэг даалгавар өгсний дагуу хэрэгжилтийг хангуулах ажлын төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг хангуулан ажиллав.

Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан төлөвлөгөө, нэгдсэн удирдамжаар гүйцэтгэл, нийцлийн 9 сэдвээр, орон нутгийн ИТХ-ын захиалгаар 2 сэдвээр, санхүүгийн тайлангийн аудитаар 195, бүгд 206 тайланд аудит хийсэн байна.

Тайлант хугацаанд 377 төрлийн 2974.3 сая төгрөгийн зөрчил илүүлснээс 118 төрлийн 1233.6 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулсан.

Мөн 216 төрлийн зөвлөмж өгснөөс 207 төрлийн зөвлөмжийг хэрэгжүүлэн биелэлт 95.8 хувь, 62 төрлийн 1108.4 сая төгрөгийн албан шаардлага өгч 57 төрлийн 985.8 сая төгрөгийн албан шаардлагыг биелүүлэн хэрэгжилт 88.9 хувь, 16 төрлийн 310.4 сая төгрөгийн төлбөрийн актаас 15 төрлийн 156.9 сая төгрөгийг барагдуулж, биелэлт 50.5 хувьтай гарсан байна. Аудитаар тавигдсан төлбөрийн актаас 13.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүллээ.

Байгууллага, аж ахуйн нэгж өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хөрөнгөө хэмнэсэн, үр ашгаа дээшлүүлсэн, гарцын чанарыг сайжруулсан бол аудитаас үр өгөөж бий болсон гэж үзэж, үр өгөөж тооцон ажиллаа.

Энэ онд хийсэн аудитаар 1303.3 сая төгрөгийн аудитын үр өгөөжийг бүртгэн тухайн байгууллагуудын удирдлагаар хүлээн зөвшөөрүүлэн, төсвөөс авсан санхүүжилтийн 1 төгрөгийн хариуд 5 төгрөг 50 мөнгөний үр өгөөж бий болгосон байна.

Хоёрдугаар бүлэг.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

2.1 Санхүүгийн тайлангийн аудитаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар ОННТайлан, 19 сумын ТТЗ-ын нэгтгэсэн тайлан, 149 төсвийн шууд захирагч, 26 аж ахуй нэгж, нийт 195 байгууллагын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийж, СТАУС програмд 100 хувь гүйцэтгэлтэй оруулсан.


Аудитаар нийт 1759.8 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлэн 985.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулж, 14 төрлийн 8.3 сая төгрөгийн акт тавьсанаас 13 төрлийн 7.9 сая төгрөгийн актыг барагдуулан биелэлт 95.2 хувь, 39 төрлийн 201.9 сая төгрөгийн албан шаардлага өгснөөс 36 төрлийн 142.2 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлэн биелэлт 70.4 хувь, 172 төрлийн зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан.

Тайлант онд актын 3.5 сая төгрөг, албан шаардлагын 59.7 сая төгрөг үлдэгдэлтэй гарсан байна.

Аудитаар 111.7 сая төгрөгийн өртгөөр 8360 хүн цаг ажиллаж, 65.0 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж хүлээн зөвшөөрүүлсэн байна.

Урд оны аудитын үлдэгдэл 3 төрлийн 3.1 сая төгрөгийн акт, 1 төрлийн 51.1 сая төгрөгийн албан шаардлагыг барагдуулаагүйд холбогдох хүмүүст хариуцлага тооцуулахаар 4 албан шаардлага хүргүүллээ.

Дараах графикаар санхүүгийн тайлангийн аудитын 3 жилийн статистик мэдээг харуулав.




Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн тайланд 0.6 сая төгрөгийн алдааг залруулж, 49.8 сая төгрөгийн албан шаардлага өгч тооцоолсон материаллаг түвшингээс бага байгаа учир “Зөрчилгүй” санал дүгнэлтийг өгсөн.

Тайлант онд 46 байгууллагад итгэл үзүүлэн СТАУС програмд тайланг 100 хувь татан оруулсан байна.

Нийт 135 тайланд бие даан дүгнэлт гаргаснаас 129 зөрчилгүй дүгнэлт, 6 хязгаарлалттай дүгнэлт өгсөн байна.

МУЕА-ын тушаалаар батлагдсан 60 байгууллагын санхүүгийн тайланд түүврийн аргаар аудит хийлээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/104 дүгээр тушаалаар Төрийн аудитын байгууллагын нэрийн өмнөөс гэрээний үндсэн дээр орон нутгийн өмчит 26 аж ахуй нэгжид Дөлгөөнхайрхан-Уул аудит ХХК, Б энд С аудит ХХК-иуд аудитыг гүйцэтгэж, аудитын явцад орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр 0.5 сая төгрөгийн төлбөрийн акт, 4 төрлийн 7.8 сая төгрөгийн албан шаардлага, 10 төрлийн 9.8 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлж, 0.4 сая төгрөгийн үр өгөөжийг тооцон хүлээн зөвшөөрүүлсэн байна.



Санхүүгийн тайлангийн аудитаар “Хязгаарлалттай” дүгнэлт авсан 6 байгууллагын холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцуулахаар аймгийн Засаг даргад албан шаардлагыг хүргүүлж, аймгийн Засаг даргын 2016 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн № а/288 тоот захирамжаар Баруунбаян-Улаан сумын Цэцэрлэгийн эрхлэгч Т.Долгорсүрэн, нягтлан бодогч Н.Мөнхжаргал, Богд сумын ЕБСургуулийн захирал Д.Цэрэнлхам, Богд сумын Эмийн эргэлтийн сангийн эрхлэгч Б.Дондов, Уянга сумын ЗДТГ-ын нягтлан бодогч А.Должинсүрэн, Уянга сумын Жаргалантын бага сургуулийн захирал О.Мөнхтуяа, Есөнзүйл сумын Сум дундын эмнэлгийн дарга Н.Баттулга, нягтлан бодогч Ж.Чинтогтох нарт албан тушаалын цалинг 1 сарын хугацаатай 20.0 хувиар бууруулах арга хэмжээ авч хэрэгжилтийг хангуулж ажилласан байна.

## 2.2 Завсрын аудитаар:

Тайлант 2017 онд орон нутгийн болон улсын төсвийн 60 байгууллагын санхүү, бүртгэл, дотоод хяналтын үйл ажиллагаанд завсрын аудитыг хийхэд 55 байгууллагад зөрчил илэрч, 5 байгууллага зөрчилгүй гарчээ. Тус аудитаар нийт 82.4 сая төгрөгийн зөрчил илэрч, 81.8 сая төгрөгийн албан шаардлага, 0.6 сая төгрөгийн зөрчилд акт тавьж, нийт 133 зөвлөмж өгсөн байна.

## 2.3 Аймгийн 2016 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар:

Сангийн яамнаас Өвөрхангай аймгийн 2016 оны төсвийн суурь орлогыг 7914.1 сая төгрөгөөр, суурь зарлагыг 20352.1 сая төгрөгөөр, санхүүгийн дэмжлэгийг 12438.0 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийг 41238.7 сая төгрөгөөр, аймгийн ОНХСанд олгох орлогын шилжүүлгийг 4444.6 сая төгрөгөөр хянасан байна.

Аймгийн дүнгээр орон нутгийн төсвийн орлогыг 9805.5 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 10917.1 сая төгрөг оруулж 111.3 хувиар буюу 1111.6 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ. Орон нутгийн төсөвт орсон нийт татварын орлогын 77.2 хувийг аймгийн төсөвт, 22.8 хувийг сумын төсөвт оруулсан байна.

Аймгийн төсвийн нийт зарлагыг 2016 онд 72970.4 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 70884.4 сая төгрөг зарцуулан, 2086.0 сая төгрөгийн хэмнэлттэй буюу 97.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Өвөрхангай аймгийг төсвийг үндэслэлтэй төлөвлөж орлого нийт дүнгээр давж, төлөвлөсөн зардлыг хэмнэсэн байна. Аудитаар нийт 8 хүн өдөр ажиллаж 0.5 сая төгрөгийн аудитын зардал гарсан байна.

## Гуравдугаар бүлэг.

### ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Гүйцэтгэлийн аудитаар ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар болон аймгийн ИТХ-ын хүсэлт, захиалгаар тайлант хугацаанд 5 сэдвийн хүрээнд аудит хийж, 19 байгууллага, давхардсан тоогоор 9 сумдыг хамруулан 1 төрлийн 5.6 сая төгрөгийн акт, 5 төрлийн 169.7 сая төгрөгийн албан шаардлага, 18 төрлийн зөвлөмж өгснийг тус бүр 100.0 хэрэгжүүлсэн байна.

Тус аудитаар 62.5 сая төгрөгийн өртгөөр 7056 хүн цаг ажиллаж, 212.3 сая төгрөгийн үр өгөөж хүлээн зөвшөөрүүлсэн байна.

Урд оны аудитын үлдэгдэл 3 төрлийн 16.1 сая төгрөгийн акт барагдуулаагүйд холбогдох хүмүүст хариуцлага тооцуулахаар 3 албан шаардлага хүргүүллээ.

### **3.1 Тус аймагт 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг, Засгийн газраас олгосон векселийн үр дүнд хийсэн аудитаар:**

Хөрөнгө оруулалтын ТАХ-ний гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт, гэрээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна гэсэн дүгнэлт өгч 3 төрлийн 147.2 сая төгрөгийн албан шаардлага бичиж, 187.3 сая төгрөгийн үр өгөөж тооцон, холбогдох албан тушаалтнаар хүлээн зөвшөөрүүлсэн байна. Аудитаар нийт 185 хүн өдөр ажиллаж 6.1 сая төгрөгийн аудитын зардал гарсан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалт, зарим төсөл арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлоогүй байна. Үүнд:

- Арвайхээр сумын төв замын гэрэлтүүлэг 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, гэрлэн чимэглэл нэмэгдүүлэх ажлын гүйцэтгэгчээр Арвайн эрчим ХХК-ийг шалгаруулж, 79.6 сая төгрөгөөр гүйцэтгэсэн ба гэрэлтүүлгийн шонг солихгүйгээр LED гэрэл толгойн хамт суурилуулсан бол хамгийн багадаа 40.1 сая төгрөг хэмнэх тооцоо гарсан.
- Арвайхээр сумын 12, 24, 36,48, 52 айлын орон сууцууд болон Найрамдал хотхоны байруудын хуучин хаалгыг сольж кодтой төмөр хаалга суулгасан нь оршин суугчдын хүсэл шаардлагад нийцээгүй хаалга суулгасан.
- Бүсийн оношилгоо эмчилгээний төв, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд тоног төхөөрөмж нийлүүлэх тендер шалгаруулалтын техникийн тодорхойлолтыг аймгийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсээс Худалдан авах ажиллагааны албанд хүргүүлэхдээ БОЭТ-д нэн шаардлагатай коагуляцийн аппарат, наркозны аппарат, судас тодруулагч, тариурын шахуурга зэргийг захиалсан ч захиалгад ороогүй тоног төхөөрөмжүүдийг бэлтгүүлэхээр захиалсан байна.

**Улсын төсөв:** БСШУСЯ-аас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд 376.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг тус аймгийн сургууль цэцэрлэгүүдэд хуваарилсан хуваарийг аймгийн БСУГ-т ирүүлсэн байна. Гэтэл хуваарилагдсан тоног төхөөрөмжөөс нийт 9 цэцэрлэг, 1 ЕБС-д бүгд 26.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж ирээгүй байхад БСУГ хэрэгжилтэд хяналт тавиагүй байна.

**Орон нутгийн төсөв:** Сүвэн-Уул ХХК нь БОЭТ, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд тоног төхөөрөмж нийлүүлэх тендер болон гэрээнд заасан үзүүлэлтийг хангаагүй тоног төхөөрөмжийг БОЭТ-д нийлүүлсэн байхад гэрээтэй тулгаж үзээгүй, комисст гэрээ байгуулсан ажилтан оролцоогүй, хүлээж авсан байна.

### **3.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын судалгаа, мэдээллийг хугацаанд нь хүргүүлсэн.**

Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр 2016 онд суутган төлөгч хувь хүн 20, хуулийн этгээд 229 бүртгүүлсэн байна. Худалдан авалтын баримт олголттой холбоотой ирүүлсэн гомдлоор баримт олгоогүй гэж 2016 онд 13 хүн, 2017 онд 29 хүн гомдол гаргасныг шийдвэрлэжээ.

Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтоор хүсэлт гаргасан 2016 онд 59.7 сая төгрөгөөс буцаан олгосон 12.3 сая төгрөг байна.

### **3.3 Татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар 2015-2016 онд хууль тогтоомжийн дагуу олгосон хөнгөлөлт, чөлөөлөлтийн судалгааг гаргаж хүргүүлсэн.**

2015 онд аж ахуйн нэгжийн орлогын албан татвараар хөнгөлж, чөлөөлсөн орлого 244.3 сая төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвараар чөлөөлсөн 6550.7 сая төгрөг, хүн амын орлогын албан татвараар хөнгөлж, чөлөөлсөн 918.0 сая төгрөг байна.

2016 онд аж ахуйн нэгжийн орлогын албан татвараар хөнгөлж, чөлөөлсөн орлого 303.5 сая төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвараар чөлөөлсөн 4593.2 сая төгрөг, хүн амын орлогын албан татвараар хөнгөлж, чөлөөлсөн 942.2 сая төгрөг байна

### **3.4 Концессийн тухай хуулийн хэрэгжилтээр хийх аудитын тухайд тус аймагт концессоор хийгдсэн төсөл, арга хэмжээ байхгүй байв.**

**3.5 Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар:** Өвөрхангай аймагт Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж байна гэсэн ерөнхий дүгнэлт өгсөн.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулагдсан зарим хөрөнгө болох 4.0 сая төгрөгийг ойн арга хэмжээнд, үйл ажиллагааны зардалд 2.2 сая төгрөг, зочин төлөөлөгчийн буудлын зардалд 0.4 сая төгрөг, бэлэг дурсгалд 0.4 сая төгрөг, 3.0 сая төгрөгийг цагдаагийн байгууллагын бүсийн сургалт, спортын өдөрлөгт зориулалт бус зарцуулсан байна.

Тус аудитаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төсөвлөсөн хөрөнгийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлд нийцүүлж, зориулалтын бусаар зарцуулахгүй байх гэсэн 1 зөвлөмжийг өгч 9.6 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлэв.

### **3.6 Орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах талаар:**

Тус газраас 2018 оны орон нутгийн төсвийн орлогыг 2 төрлийн 275.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, зардлыг 4 төрлийн 1121.1 сая төгрөгөөр бууруулах саналыг аймгийн ИТХурал, ЗДТГ-т хүргүүлсэнээс төсвийн орлогыг 2 төрлийн 91.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, зардлыг 1 төрлийн 14.0 сая төгрөгөөр бууруулах саналыг хүлээн авсан байна.



**Дөрөвдүгээр бүлэг.**

**НИЙЦЛИЙН АУДИТ**

Нийцлийн аудитаар УАГ-ын нэгдсэн удирдамж болон аймгийн ИТХ-ын хүсэлт, захиалгаар тайлант хугацаанд 6 сэдвийн хүрээнд аудит хийж, 42 байгууллага, давхардсан тоогоор 12 сумдыг хамруулан 1 төрлийн 296.5 сая төгрөгийн акт тавьсанаас 1 төрлийн 143.1 сая төгрөгийн актыг хэрэгжүүлж, 18 төрлийн 736.8 сая төгрөгийн албан шаардлага өгснөөс 16 төрлийн 673.9 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлж, 26 төрлийн зөвлөмж өгсний 17 төрлийн зөвлөмжийг хэрэгжүүлж, актын 153.1 сая төгрөг, албан шаардлагын 62.9 сая төгрөг, 9 зөвлөмж хэрэгжээгүй буюу хэрэгжих шатандаа үлдэгдэлтэй гарсан байна.

Тус аудитаар 62.1 сая төгрөгийн өртгөөр 7054 хүн цаг ажиллаж, 1026.0 сая төгрөгийн үр өгөөж хүлээн зөвшөөрүүлсэн байна.

**4.1 Орон нутгийг хөгжүүлэх сангийн зарцуулалт, үр дүнд хийсэн аудитаар:**

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу зохион байгуулсан ч сангийн хөрөнгийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, дотоод хяналт хангалтгүй байна гэсэн дүгнэлт өгч аудитаар 729.5 сая төгрөгийн үр өгөөж тооцож, 17 төрлийн 729.5 сая төгрөгийн албан шаардлагыг аймаг, сумдад хүргүүлсэнээс 15 төрлийн 666.6 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлж, 2 төрлийн 62.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитаар ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд дараах зөрчил гарсан байна. Үүнд:

1. Зориулалт бусаар 14 төсөл арга хэмжээнд 79.1 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан.
2. 11 төсөл арга хэмжээний 531.6 сая төгрөгийн ажил дутуу буюу чанаргүй хийгдсэн, хугацаа хэтэрсэн.
3. 4 төсөл арга хэмжээний 42.3 сая төгрөгийн ажил хийгдээгүй.

Аудитаар нийтдээ 34 төсөл арга хэмжээтэй холбоотой 729.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага тавигдсан болно.



**Зураг 3: Арвайхээр сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн ажил хугацаандаа дуусаагүй байна.**

График 1: Өвөрхангай аймгийн 2016 оны ОНХС-ийн аудитаар илэрсэн зөрчлийн төрлөөр

/сая төгрөг/



#### 4.2 Өвөрхангай аймагт 2013-2014 онд Идлэг шонхор шувуу барих, гадаад оронд гаргах үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд аудитаар:

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1.2-д ахуйн, үйлдвэрлэл, соёл, шинжлэх ухааны зориулалтаар агнасан бусад ан амьтны төлбөрийг тухайн ан амьтны толгой тутмын экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40 хувиар гэж заасны дагуу ЗГ-ын 2011 оны 01 дүгээр сарын 25-ны №23 тогтоолоор “Үнэлгээ, төлбөр, хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай” шийдвэрээр ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг идлэг шонхор шувууг 16000.0 мянган төгрөгөөр тогтоосон байна.

Үүнийг үндэслэн Өлзийт сум 1 идлэг шонхрын экологи эдийн засгийн үнэлгээний 40.0 хувь болох 6400.0 мянган төгрөгийн төлбөрийн орлогыг сумын төсвийн орлогын дансанд, Есөнзүйл сум 4 идлэг шонхрын экологи эдийн засгийн үнэлгээний 40.0 хувь болох 25600.0 мянган төгрөгийн төлбөрийн орлогыг сумын төсвийн орлогын дансанд тус тус оруулсан байна.

Харин өгөөшийн төлбөрөөр орон нутгийн төсвийн орлогын дансанд орлого ороогүй болно. Өгөөш болох тагтаа шувууг барьсан талаар баримт, мэдээ байхгүй байна.

Орон нутагт Идлэг шонхор шувуу экспортын зориулалтаар барихад холбогдох төр, захиргааны байгууллагуудын хяналт хангалтгүй байжээ.


**4.3 Өвөрхангай аймагт Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулахаар улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд хийсэн аудитаар:** Өвөрхангай аймгийн сонгуулийн хороо Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгууль зохион байгуулах зардлыг холбогдох журмын дагуу зарцуулж, тайлагнасан байна гэсэн дүгнэлтийг өгсөн.

Сонгуулийн хороод төсвийг зориулалтын дагуу захиран зарцуулсан ч анхан шатны санхүүгийн баримтын бүрдэл дутуу 4.3 сая төгрөгийн алдааг залруулж, анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой зөрчилд 1 зөвлөмж өгсөн болно. Тус аудитаар 3 хүн 15 өдөр ажилласан.

**4.4 Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар:** Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа хууль, журамд заасан шаардлагыг хангасан ч төсвийг бодитой тооцох, аймаг, сумдыг хөгжүүлэх хэтийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх шаардлагатай байна гэсэн дүгнэлтийг өгсөн.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш аймгийн хэмжээнд нийт 74 бодлогын баримт бичиг боловсруулан баталсан байна.

Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 он хүртэл хөгжүүлэх бодлогын баримт бичгийг дараах байдлаар тодорхойлжээ.



Сумдын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл боловсруулахдаа хүрэх үр дүнг төсвийн нөөц боломжтой уялдуулах, санхүүгийн тооцооллыг бодитой тусгаагүйгээс зарим заалт хэрэгжээгүй байна.


Аймаг, сумдад хэрэгжиж буй хөгжлийн бодлогын баримт бичгүүд нь журмын дагуу төлөвлөж, боловсруулсан ч хуулийн хугацааг анхаарч үзэх, аймаг, сумдыг хөгжүүлэх хэтийн төлөвлөгөөнд хяналт шинжилгээ үнэлгээ хийх, хэрэгжилтийг тайлагнах шаардлага байна.

Сумдад хэрэгжиж буй бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг нийтэд мэдээлэх ажлыг сайжруулах нь зүйтэй байна гэсэн дүгнэлтийг өгч, аймаг сумдын Засаг дарга нарт 5 зөвлөмжийг өгсөн.

**4.5 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар:** Өвөрхангай аймагт Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалттай байгаа ч хөндлөнгийн хяналтыг сайжруулах шаардлагатай байна гэсэн дүгнэлийг өгөв.



Өвөрхангай аймгийн ТЕЗахиаргчийн хэмжээнд аудитад хамрагдсан байдал **График-1**



Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээг Төсвийн ерөнхийлөн захирагчийн 244 байгууллагын хэмжээнд нийт 2521 төрлийн гүйлгээнээс 2493 төрлийн 104011.0 сая төгрөгийн гүйлгээг мэдээлж, 28 төрлийн 983.3 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байна. Үүнд. Хархорин сумын Тариалан эрхлэлтийг дэмжих сан 12 төрлийн 157.6 сая төгрөг, Хужирт сумын Соёлын төв 2 төрлийн 21.4 сая төгрөг, аймгийн Онцгой байдлын газар 9 төрлийн 767.9 сая төгрөгийн санхүүжилт дутуу мэдээлсэн байна. Аудитын явцад дараах 20 байгууллагуудын 154 төрлийн 3684.0 сая төгрөгийн орлогын гүйлгээг залруулан, мэдээллийг байршууллаа.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.9-д заасан мэдээллийг журмын дагуу мэдээлсэн байна.

Аудитын хамрах хугацаанд  
34 ААНэгж нийт 3816.4 сая төгрөгийн  
төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээ

Үүнээс олгосон 2715.2 сая  
төгрөгийн санхүүжилт олгосон

Аудитаар аймаг, сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, байгууллагын дарга, эрхлэгч нарт 4 зөвлөмж өгсөн.

**Тавдугаар бүлэг.**

**ИТХ-ЫН ХҮСЭЛТЭЭР БОЛОН ӨӨРИЙН  
САНААЧЛАГААР:**

Аймгийн ИТХурлын хүсэлтээр Өмчийн хэлтсээс 2013-2016 оны хооронд зохион байгуулсан дуудлага худалдаа, оролцогчдын хураамжийн зарцуулалтын үр дүнд гүйцэтгэлийн аудит, Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр 2016 онд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд нийцлийн аудитыг хийв.

### **5.1 Өмчийн хэлтсээс 2013-2016 оны хооронд зохион байгуулсан дуудлага худалдаа, оролцогчдын хураамжийн зарцуулалтын үр дүнд хийсэн аудитаар:**

Дуудлагын худалдааг журмын дагуу зохион байгуулж байгаа ч бэлтгэл ажил хангалтгүй, худалдсан хөрөнгийн орлогыг хугацаанд нь төсөвт төвлөрүүлээгүй, оролцогчдын хураамжийг үрэлгэн зарцуулсан байна гэсэн дүгнэлт өгч аудитаар 25.0 сая төгрөгийн үр өгөөж тооцож, 12.6 сая төгрөгийн албан шаардлага өгч, 5.6 сая төгрөгийн акт тогтоосон хэрэгжих шатандаа байна. Аудитаар нийт 185 хүн өдөр ажиллаж 6.1 сая төгрөгийн аудитын зардал гарсан.

Аудитад хамрагдсан тайлант онуудад дуудлагын худалдаанд оролцогчдын хураамжаас нийт 20.9 сая төгрөг төвлөрсний 6.5 хувийг зар сурталчилгааны төлбөрт, 6,6 хувийг үнэлгээ хийлгэсний хөлсөнд, 4.7 хувийг бичиг хэрэг, шуудан холбооны зардалд, 46.8 хувийг шатахуун, сэлбэг хэрэгслийн зардалд, 26,6 хувийг хоол хүнс, архи дарс, чихэр жимс худалдан авахад, 8.8 хувийг бусад зардалд зарцуулжээ.

Дуудлагын худалдааны хураамжийн орлого, зарлагад бэлэн мөнгөний гүйлгээний тайлангаас өөр бүртгэл хөтлөгдөхгүй, гүйлгээг санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгахгүй, зөвхөн хэлтсийн даргын мэдлийн хүрээнд зарцуулагдаж ирсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийг зөрчсөн байна.

**5.2 Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр 2016 онд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн хууль, тогтоомжид нийцсэн эсэхэд аудитыг явуулж, Өвөрхангай аймгийн ХЭДСангийн 2016 оны орлогын бүрдүүлэлт, хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн хангалтгүй байна гэсэн дүгнэлтийг өгсөн.**

Аудитаар 296.5 сая төгрөгийн үр өгөөж тооцон хүлээн зөвшөөрүүлж, 7.3 сая төгрөгийн албан шаардлага тавьсаныг хэрэгжүүлж, 296.5 сая төгрөгийн акт тогтоож 143.4 сая төгрөг буюу 48.3 хувийн актыг барагдуулсан байна. Аудитаар байгууллагын удирдлагад 6 зөвлөмж өгч хэрэгжилтийг бүрэн хангуулсан байна.

**Зургаадугаар бүлэг.**

**БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АЖЛЫН ТАЛААР:**

Тайлангийн хугацаанд тус газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторын 25 тушаал гаргаж, явсан бичиг 292, ирсэн бичиг 361 бүртгэж, хариутай 37 албан бичгийг хугацаанд шийдвэрлэсэн байна. Мөн ҮАГ-аас дотоод сүлжээгээр танилцуулагдсан мэдээ, мэдээлэл, сургалтад тогтмол оролцон үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр хангаж ажиллаа.

Монгол улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл, Аудитын иргэний танхим болон Аудитын иргэдийн бүлгийн үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт, чиглэл, төсөв, санхүүжилтийн журмын төсөл, “Төрийн аудитын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг”-ийн төсөл, Санхүүгийн тайлангийн аудитын болон Нийцлийн аудитын журмын төсөл, Ажилтнуудын ажлын байрны чиг үүрэг, тавигдах шаардлага, хүчин зүйлсийн талаарх төсөл, Төрийн аудитын байгууллагын хэмжээнд мөрдөгдөж буй стандарт, дүрэм, журам болон түүнийг шинэчлэн боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр мөрдөгдөх стандарт, дүрэм, журмуудад өгөх санал, төсөлтэй танилцаж, хэлэлцүүлгийг ажилтнуудын дунд зохион байгуулж, хурлын тэмдэглэл, саналыг хугацаанд нь ҮАГ-т хүргүүлэв.

Төрийн аудитын байгууллагын 2019-2023 онд хийх аудитын хэтийн төлөвлөгөөнд тусгуулж нэгдсэн удирдамжаар гүйцэтгэх, мөн өөрийн болон ИТХ-ын санаачлагаар аудит хийх саналаа хүргүүлсэн болно.

Сар бүрийн үйл ажиллагааны тайлан мэдээ, аудитын сэдвийн санал, сургалтад хамрагдах ажилтнуудын судалгаа, хүний нөөцийн судалгаа, боловсон хүчний цаг ашиглалт, ирцтэй холбоотой мэдээ, мэргэшсэн нягтлан бодогчийн судалгаа зэргийг гаргаж хүргүүлсэн байна.

Өөрийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгож мэдээллийн самбарт үндсэн ажлын чиг үүрэг хийсэн ажлын товч тайлан, төсвийн зарцуулалтын мэдээ, шалгагдагч байгууллагын талаарх мэдээлэл, санхүүгийн тайлангийн аудит хийх хуваарь зэрэг холбогдох мэдээллийг тухай бүр шинэчлэн тавьж ил тод байдлыг хангаж ажилласан. Байгууллагын вэйб сайт <http://www.audit.ov.gov.mn/>-д засвар хийж ашиглалтад оруулан, тухайн онд хийсэн аудитууд, акт, албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилтийг ил тод нээлттэй байдлаар тавьж, хэвшээд байна. Мөн ҮАГ-ын нэгдсэн сайт <http://www.audit.mn/>, өөрийн орон нутгийн, <https://www.facebook.com/uvurkhangai.audit> сайтуудад аудитын шалгалтын дүнгийн талаарх товч тайлан, цаг үеийн мэдээллүүдийг тогтмол тавьж ирснээр нийт хандалтын тоо 1905 хүнд хүрсэн байна.

Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны 3 өдрийн уулзалт зөвлөгөөнд дарга бөгөөд тэргүүлэх аудитор, аудитын менежер нар амжилттай оролцсон байна. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас орон нутгийн төрийн албан хаагчдыг чадавхжуулах "Захиргааны ерөнхий хууль"-ийн сургалтад 3 албан хаагч хамрагдсан.

Нэгдсэн удирдамжаар хийгдэж буй аудит болон бусад дотоод ажлын хүрээнд ҮАГ-аас онлайнээр зохион байгуулсан 11 удаагийн мэдээлэлд 11 албан хаагч бүрэн хамрагдаж, СТАУС 2 програм ашиглан санхүүгийн тайлангийн аудитыг хэрхэн хийх талаар сургалтыг ҮАГ-ын ахлах аудитор Ж.Батсайханыг аймагтаа урьж Баянхонгор аймгийн аудитын газрын албан хаагчдын хамт сургалт зохион байгуулсан.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийтлэг гарч буй зөрчил 2017 оны аудитаар юунд анхаарах талаар сургалтыг ахлах аудитор Ж.Нямаа албан хаагчдад сургалт хийсэн.

Төрийн аудитын байгууллагын бүсчилсэн сургалтад Төв аймгийн Баянчандмань суманд 09 дүгээр сарын 19-24-ны өдрүүдэд 11 албан хаагч оролцож, Төрийн болон албаны нууцын тухай хууль, тогтоомжийн талаарх сургалтыг ТЕГ-аас 2017 оны 11 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд зохион байгуулсан сургалтад нууцын ажилтан, ахлах аудитор Ц.Отгонням 1 өдрийн, 11 ажилтан хагас өдрийн сургалтад, аудитор Ч.Гантулга мэдээллийн технологийн 3 хоногийн сургалтад тус тус хамрагдав.

Өвөрхангай аймгийн Засаг даргын санаачилсан Санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх зөвлөгөөн зохион байгуулахад тус газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор орон нутгийн төсөвт байгууллагын нийтлэг гарч буй зөрчлийн талаар урилгаар илтгэл тавьж зөрчилтэй дүгнэлт авсан албан тушаалтанд хариуцлага тооцох, санал хүргүүлж төрийн аудитын байгууллага санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэхийг уриалсан.

Ажилтнуудаас хувийн ашиг сонирхолын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахимаар болон цаасаар хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажуулсан мөн аудит хийх тухай бүр ашиг сонирхолгүйн зөрчилгүй мэдэгдлийг гаргуулж ажилласан.

Тайланд оны эхэнд 11 ажилтнаас нууцын баталгаа гаргуулан авч, төрийн нууцад хамаарах Зэвсэгт хүний ангиудын санхүүгийн тайланг нууцын ажилтнаар дамжуулан хүлээн авч холбогдох аудиторуд аудит хийж, материалыг нууцын ажилтан нууцын архивт хадгалан тухай байгууллагад аудитлагдсан тайланг хүргүүлсэн байна.

Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажлын стресс тайлах, өвлийн улиралд ханиад томуунаас урьдчилан сэргийлж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор санхүүгийн тайлангийн аудитын ачаалал ихтэй 1-4 дүгээр саруудад ВИТАМИНЖУУЛАХ аян зохион байгуулан, өдөр бүр халуун чацаргана, олон төрлийн витаминаар үйлчилгээ үзүүлэн 0.3 сая төгрөгийг албан хаагчдын бие эрүүл мэндэд зориулан зарцуулсан болно.

Мөн хамт олны санаачлагаар “Хамт олны хуримтлалын сан”-г бий болгон өнгөрсөн жилээс эхлэн сар бүр 10-30 мянган төгрөгийг цалингаас суутгуулан, тодорхой хэмжээний мөнгөн хуримтлалтай болсон нь төсвөөс мөнгө зарцуулахгүйгээр албан хаагчдын гачигдал зовлон, зарим нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлтийн өмнөх шатны ажил болох СТАУС-д аудит явуулах байгууллагын мэдээлэл, нэмэгдсэн хасагдсан байгууллагууд, ОНХС, СХСангийн мэдээллийг оруулсан ба байгууллага, аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн тайлангийн аудитыг хариуцан гүйцэтгэх аудиторуудыг хуваарилан баталгаажуулав.

Санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын компанийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журмын дагуу зохион байгуулан сонгон шалгаруулж, Дөлгөөн хайрхан-Уул аудит ХХК, Б энд С аудит ХХК-тай гэрээ байгуулав.

Тайлант онд ахлах аудитор Д.Гансүх “Алтан гадас” одон, аудитор С.Шийлэгмаа “Төрийн хяналтын тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнагдсан.

**Долоодугаар бүлэг.**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛ:**

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг ННБ-ын тухай хуулийн дагуу дотоод хяналтыг хэрэгжүүлэн, төрийн өмчийн бүртгэл програмд хөрөнгийн бүртгэлийг бүрэн баталгаажуулан, хууль тогтоомжийн дагуу удирдан зохион байгуулж, төсвийн ил тод байдал, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлж 2017 оны байдлаар шилэн дансны цахим хуудаст 136 удаагийн мэдээлэл байршуулсан байна. Тайланд хугацаанд 236.8 сая төгрөгийн төсвийн санхүүжилт авч төсвийг зориулалтын дагуу зарцуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 439 дүгээр “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллого явуулах тухай” тогтоол, Сангийн сайдын 2016 оны 126 дугаар “Төрийн болон орон нутгийн өмчийн тооллого явуулах журам” тушаалын дагуу хагас, бүтэн жилийн өмч хөрөнгийн тооллого явуулж 102.7 сая төгрөгийн хөрөнгө тоолж ашиглах боломжгүй болсон 7 нэр төрлийн 8.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг ТӨБЗГ-ын 2017 оны №А-4/3209 тоот оор актлах зөвшөөрөл өгсөний дагуу бүртгэлээс хассан болно.

**Наймдугаар бүлэг.**

**ДҮГНЭЛТ САНАЛ**

1. Орон нутгийн аудитын байгууллагуудын техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл, хүчин чадлыг нэмэгдүүлэх.
2. Төрийн албаны тухай хууль болон байгууллагын дотоод журмын дагуу ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж байх.
3. Орон нутгийн аудитын байгууллагуудын гадаад харилцааг сайжруулах, албан хаагчдыг гадаад сургалтад хамруулах зэрэг саналуудыг дэвшүүлж байна.

ТАЙЛАН ХЯНАСАН:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЛАМААЧИН

ТАЙЛАН БИЧСЭН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ГАНСҮХ